



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/431

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний өв соёл, ёс заншлаа хадгалан хамгаалж, залуу хойч үеэ өвлүүлэн, сурталчлах зорилгоор зохион байгуулагдах Адуучин тэмцээний зардалд 2 000 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тэмцээнд зарцуулагдах 2 000 000 төгрөг /Хоёр сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.17-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлэхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

(Handwritten signature)

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
08 дугаар сарын 13-ны өдрийн
А/431 дүгээр захирамжийн хавсралт

АДУУЧИН ТЭМЦЭЭНИЙ ЗАРДАЛ

Д/д	Арга хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тамирчдад дурсгалын зүйл	50	40 000	2 000 000
	Нийт			2 000 000

-оОо-